


Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 30-ний өдрийн ^{22-А/}36 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Дархан-Уул аймгийн
Засаг даргын Тамгын газар

Нийгмийн бодлогын хэлтэс

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Ахлах түшмэл, ТЗ-4

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдрийн 8 цаг

Нутгийн удирдлагын ордон

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын стратеги төлөвлөгөө, зорилт чиг үүрэг, нийгмийн салбарын бодлогын хэрэгжилтийг хангах, хяналт тавих, удирдлагад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, бодит мэдээ мэдээллээр хангах, нэгжийн үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангаж, гүйцэтгэлийн үр дүнг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- 1.Боловсрол, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн оновчтой менежментийг нэвтрүүлэх, нэгдсэн бодлого зохицуулалтаар хангах, хяналт тавих;
2. Хүн амын хөгжил, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын салбар, жендерийн эрх тэгш байдлыг хангах талаар төрөөс баримтлах бодлогыг нэгдсэн зохицуулалтаар хангуулах, үйл ажиллагааг зохион байгуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавих;
- 3.Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын хөгжлийг дэмжсэн бодлогыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх, салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлэх, үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;
- 4.Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Аймгийн боловсрол, шинжлэх ухааны бодлого, стратегийг төлөвлөх, үндэсний хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх, орон нутгийн дэд хөтөлбөрүүдийг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах.	Стратеги болон бодлого төлөвлөж, хууль тогтоомж, тогтоол шийдвэрт нийцүүлэн хэрэгжилтийг хангах.	Х,Т,Ш
	3.Боловсрол салбарын бодлогыг тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгах, хэрэгжилтийг зохион байгуулах.	Жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангана.	Х,Т,Ш
	3.Аймгийн хэмжээнд сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол олгох байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн бодлого, зохицуулалтаар хангах, дэмжлэг үзүүлж, удирдлагаар хангах	Салбарын хөгжлийн бодлого болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдсан байна.	Х,Т,Ш
	4.Төрийн өмчийн болон өмчийн бусад хэлбэрийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, насан туршийн боловсролын төвийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлж дүгнэх	Боловсролын багц хуулиудын хэрэгжилтийг хангасан байна.	Х,Т,Ш

	5.Эрүүл мэндийн хөгжлийн стратегийг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах	Стратеги болон бодлогын баримт бичиг, зөвлөмж, шийдвэрийн төсөл, тооцоо, дүгнэлт, тайлбар, танилцуулга, судалгаанууд бодит мэдээлэлд үндэслэгдсэн байна.	Х,Т,Ш
	6.Аймгийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар баримтлах бодлогыг тодорхойлж, төлөвлөлтөд тусгах, хэрэгжилтийг зохион байгуулах	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад шууд чиглэсэн байна.	Х,Т,Ш
	7.Аймгийн хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр гаргасан үндэсний хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх хүрээнд орон нутгийн дэд хөтөлбөрүүдийг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг үнэлэх	Салбарын хөгжлийн бодлого болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдсан байна.	Х,Т,Ш
	8.Аймгийн хэмжээнд нийгмийн үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн бодлого, зохицуулалтаар хангах, мэргэжлийн зөвлөгөө өгөх, арга зүйн дэмжлэг үзүүлэх, захиргааны удирдлагаар хангах	Эрүүл мэндийн багц хуульд нийцсэн байна.	Х,Т,Ш
2 дугаар зорилтын хүрээнд	1.Иргэдийн ажилгүйдэл ядуурлын талаар судалгааг холбогдох байгууллагаас гаргуулан авч, бодлого төлөвлөлт хийх.	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад шууд чиглэсэн байна.	Х,Ш
	2.Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, ажлын байр бий болгох асуудлаар шийдвэр гаргах, бодлого боловсруулахад үнэн зөв мэдээлэл, зөвлөгөө, дэмжлэгээр хангах.	Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах чиглэлээр бодит үр дүнд хүрсэн байх.	Х,Ш
	3.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох, авьяас ур чадвараа хөгжүүлэх, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох	Салбарын хөгжлийн бодлого болон аймгийн Засаг даргын үйл	Х,Т,Ш

	боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр бодлого боловсруулах, үр дүнд хяналт тавих.	ажиллагааны хөтөлбөртэй уялдсан байна.	
	4.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөө ажиллах төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангуулах, хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэх, хүртээмжтэй орчин бий болгох.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжсэн байна.	Х,Т,Ш
	5.Орон нутаг дахь байгууллагуудын жендерийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөх, бодлого зохицуулалтаар хангах, дэд хөтөлбөр болон төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох, тайлагнах	Орон нутгийн бүх шатны байгууллагуудын үйл ажиллагаа жендерийн тэгш байдлыг хангасан байна.	Х,Т,Ш,Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Соёл, спортыг дэмжих бодлогыг, орон нутгийн бодлогын баримт бичигт тусгах, хэрэгжилтийг зохион байгуулах	Бодлогын хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х, Ш
	2.Залуучуудын хөгжил, хамгааллын талаарх бодлого, стратегийг төлөвлөх, үндэсний хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, хянах, тайлагнах;	Залуучуудын хөгжил, хамгаалал нэмэгдэж үр дүнд хүрсэн байна.	Т, Г,Х
	3.Орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого, төлөвлөлтийг боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах	Орон нутагт аялал жуулчлал хөгжүүлэх бодлого тодорхойлогдож, хэрэгжүүлсэн байна.	Т, Г,Х
	4.Ардын авьяастнуудыг дэмжих, сурталчлах, тэдний бүтээл урлалыг өвлөн уламжлах, нийтийн хүртээл болгоход чиглэсэн арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, удирдлагаар хангах	Салбаруудын дэд хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлсэн байна.	Х,Т,Ш
	5.Түүх, соёлын дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах ажлыг зохион байгуулах	Түүх өв уламжлалыг хамгаалах чиглэлээр дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангасан байна.	Х,Т,Ш
	6.Нийгмийн салбарын хамтын ажиллагааг хөгжүүлж, хамтран ажиллахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх.	Хамтын ажиллагаа үр дүнд хүрсэн байна.	Т, Г,Х

4 дүгээр зорилтын хүрээнд	1.Нэгжийн төлөвлөгөөг хэрэгжилтийг хангах, гүйцэтгэлийн батлуулж, тайлагнах	Гүйцэтгэлийн төлөвлөгөөг хангах талаар ажил зохион байгуулж, хэрэгжүүлсэн байна.	Т,Х
	2.Нэгжийн албан хаагчдыг мэргэшил, арга зүйн удирдлагаар хангаж, алба хаагчийн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, сар бүр төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, үнэлэх дүгнэх	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж хуульд нийцсэн зөвлөгөөгөөр хангасан байна.	Т,Х
	3.Нэгжийн ажлыг бусад нэгжийн үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулах	Нэгжийн үйл ажиллагааг уялдуулах арга хэмжээ авсан байна.	Ш,Г
	4.Шууд харьяалах албан тушаалын тодорхойлолтуудыг боловсруулж, мөрдүүлэхэд хяналт тавих	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Х,Г
	5.Нэгжийн албан хаагчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах, ажлыг зохион байгуулах	Албан хаагчдыг чадавхжуулах ажил хийгдсэн байна.	Х,Г
	6.Байгууллагын бичиг хэргийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримтаа хугацаанд нь шилжүүлэх	Заавар журмыг албан хэрэг хөтлөлтөд мөрдлөг болгосон байна.	Х

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.
Мэргэжил	- эрх зүй /0421/, - менежмент ба удирдахуй /0413/, - нийгмийн хамгаалал /092/, - эрүүл мэнд /0918/, - анагаах ухаан /0912/, - боловсрол /011/, - хүмүүнлэг /022/, - ахуйн үйлчилгээ (101); - социологи болон соёл судлал /0314/, - нийгмийн болон зан үйлийн шинжлэх ухаан /031/ - эрүүл мэнд, нийгмийн хамгаалалд хамаарах салбар дундын чиглэл /0988/;
Мэргэшил	Төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтад хамрагдаж, төгссөн байх.
Туршлага	Төрийн албанд 6-аас доошгүй жил ажилласан байх, үүнээс дэс түшмэл албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх. хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх.

Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг цуглуулж харьцуулах, дүгнэх, санал боловсруулах; - мэдээлэлд шинжилгээ хийх; - харьцуулсан судалгаа хийх, судалгааны үр дүнг үнэлэх, тайлбарлах; - шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх; - бодлогын үндэслэлтэй санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулах; - мэдээллийн уялдаа холбоо чиг хандлагыг олж харж чаддаг байх; - мэдээллийг түргэн шуурхай, үр дүнтэй байдлаар нягтлан судалж, нэмэлт мэдээлэл шаардлагатай эсэхийг тодорхойлдог байх; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур эрх ашиг сонирхолд үндэсний язгуур эрх ашиг сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх; - хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах; - тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах; - аливаа харилцааг зохицуулах арга замыг тогтоол, шийдвэрийн төсөлд тусгах санал боловсруулах, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх; - хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх мэдлэг, чадвартай байх; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд аливаа асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаар удирдлагад танилцуулах; - асуудлын шийдэлд шинэлэг байдлыг нэвтрүүлдэг байх; - бусад.
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - бусадтай ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - нээлттэй, шударга байх; - байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх; - Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн зарчим, нийтлэг хэм хэмжээг сахин мөрдөж, ёс зүйн шаардлагыг биелүүлэх; - шинэлэг санаа, үйлчилгээг нэвтрүүлэх, шинэ санаачилга, бүтээлч үйл хандлагыг дэмжих; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтын хувьд хамт олныг манлайлах; - харилцан бие биеэсээ суралцах, санаа бодол туршлагаа хуваалцах сэдлийг бий болгодог байх; - маргаантай асуудалд хүлээцтэй, нийцтэй ханддаг байх; - бусад.
	Бусад	<ul style="list-style-type: none"> - кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт техник, технологи ашиглах; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах;

	<ul style="list-style-type: none"> - мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэхэд санаачилгатай ханддаг байх; - харилцааны оновчтой арга хэлбэрийг ашиглаж, асуудлыг шийдвэрлэх, мэдээллийг шуурхай хүргэх; - төрийн болон хувь хүний нууцыг хууль тогтоомжийн хүрээнд хадгалах, хамгаалах.
--	---

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга.

<u>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u> <u>Ахлах мэргэжилтэн</u> <u>Мэргэжилтэн</u> <u>Төрийн үйлчилгээний албан хаагч</u> <u>Нийт</u>	<u>Бусад харилцах субъект</u> <ul style="list-style-type: none"> - Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, албаны дарга, мэргэжилтнүүд - Сумын ЗДТГ-ын дарга, мэргэжилтнүүд - Иргэн хуулийн тэгээд
---	---

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Д. Чамсасорж
 (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)
 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр

Шийдвэрийн огноо:

Дугаар: 2.15

25.0521

Албан тушаалын тодорхойлолт баталсан:

Байгууллагын нэр:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2025.06.30.

Дугаар: 62-А/56

(тамга/тэмдэг)

ДАРГА *О. Лурмануулуур*

(Гарын үсэг) (Эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр)

2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр

